



БНМАУ

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ  
ТОГТООЛ

487

1990 оны 11 сарын 29 өдөр

дугаар 285

Улаанбаатар хот

Пүүс байгуулах тухай

Тус орны эдийн засгийн гадаад харилцаа өдгөжихийн хирээр орон нутгийн төр захиргааны байгууллагууд бие даасан эдийн засгийн бодлого явуулж, гадаад орон, хотуудтай хамтран ажиллах, худалдаа хийх, бараа солилцох шаардлага гарч байгааг харгалзан Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа, түүний харьяа байгууллагуудын эдийн засгийн гадаад харилцаа, гадаад худалдаа, бараа солилцооны ажлыг хариуцан гүйцэтгэх худалдаа, үйлдвэрлэлийн "Туул импэкс" пүүсийг 1990 оны 12 дугаар сарын 1-нээс аж ахуйн тооцоон дээр ажиллуулахаар байгуулсугай.

2. Худалдаа, үйлдвэрлэлийн ажлыг эрхлэхэд зориулах валютын болон төгрөгийн эзэлийг баталгаажуулж "Туул импэкс" пүүст олгуулах арга хэмжээ авахыг Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны нэгдүгээр орлогч дарга н.Ганхуягт даалгасугай.

3. Тус пүүсийн ажилчин албан хаагчдыг 1991 оны 7 дугаар сарын 1 хүртэл цалинжуулах, захиргаа аж ахуйн зардлыг санхүүжүүлэх, үндсэн ба эргэлтийн хөрөнгийг бий болгоход зориулан 300,0 мянган төгрөгийг төсвийн орлогын төлөвлөгөө давуулан биелүүлсний хөрөнгөнөөс олгохыг Санхүүгийн газар /н.Гонгор/-т өвчөөрсугай.

4. "Туул импэкс" пүүсийн дүрэм, эхний ээлжинд мөрдөх орон нутгийн санг 1,2 дугаар хавсралтаар баталсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

*[Signature]*  
Д. ЭНЭБИШ

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

*[Signature]*  
Ч. СУМААХҮҮ

490  
100

Улаанбаатар хотны Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1990 оны 285 тоот тогтоомжийн нэгдүгээр хэсгээр

## "ТУУЛ ДИЛЕКС" ТҮҮСИЙН ҮҮРЭГ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Хуучиндаа, үйлдвэрлэлийн "Туулидилекс" нүүс нь /уламд нүүс гэнэ/ Улаанбаатар хотны Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны удирдлагын дор хотны захиргаа, түүний харьяа байгууллагуудын эдийн засаг, техникийн гаднаад харилцаа, худалдаа, бараа солилцооны аялалт хариуцан гүйцэтгэн, зуучлах үйл ажиллагааг аж ахуйн бүрэн тосгооны үндсэн дээр явуулах гаднаад худалдаа эрхэлдэг биеэ даасан хуулийн этгээд мөн.

2. Нүүс нь өөрийн үйл ажиллагааг БМАУ-ын Улсын үйлдвэрийн газрын хууль тус улсын бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийн дагуу явуулна.

3. Нүүс нь мөнгөлдөө байгаа эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хууль тогтоомжид зэвсэж хэмжээ, хязгаарыг дотор өөрийн үйл ажиллагааны зорилгын дагуу харагжуулна.

4. Нүүсийн худалдсан үүргийг улс хариуцахгүй, улс, хот болон байгууллагын худалдсан үүргийг нүүс хариуцахгүй.

5. Нүүс нь аж ахуй, сэнхүү, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагааныхаа үр дүнг Улаанбаатар хотны Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны өмнө шууд хариуцна.

6. Нүүс өөрийн нэр бүхий тэмдэг /эмблем/ бичгийн хэвлэмэл нүүр, тэмдэгтэй байна.

### Хоёр. Нүүсийн үйл ажиллагааны чиглэл, зорилт

7. Нүүс нь Улаанбаатар хотны Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа, түүний харьяа байгууллагуудын эдийн засгийн гаднаад харилцаа, гаднаад худалдаа, бараа солилцооны үйл ажиллагааг зуучлах буюу хариуцан гүйцэтгэнэ.

8. Нүүс нь Улаанбаатар хотод шинээр байгуулагдах үйлдвэрлэлийн газруудын хэрэгцээг тоног төхөөрөмж, материалыг гэрээлэн нийлүүлэхэд зуучлана.

9. Үүс нь Улаанбаатар хотын хэтийн төлөвлөгөөнд туслагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал түүнчлэн ард түмний өргөн хэрэгцээний болон соёлын ховор барааг хэрэгцээг захиалгын үнцэслэн тодорхой хэмжээгээр экспорт импортын үйл ажиллагаа явуулах, шаардлагатай үед газар дээр нь тохиролцооны үнээр худалдан авч, гадаад худалдааны нөхцөл дурмаар ханган нийлүүлнэ.

10. Хамтын үйлдвэр, үйлчилгээний газар, байгууллага байгуулж, дотоодны хэрэгцээг хангах, экспортлах барааны эх үүсвэртэй болох.

11. Гадаадын байгууллага, пүүсүүдийн төлөөлөгчдийн газраас хостод үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангах талаар туслацаа үзүүлэх, зуучлах.

12. Бусад орны хотуудын гадаад эдийн зэсэг, худалдааны асуудлыг эрхэллэгт байгууллагуудтай холбоо тогтоох, мангэлэл, ажилтан солилцох.

#### Гурван пүүсийн эсх

13. Үүс нь өөрийн үйл ажиллагаанд холбогдох асуудлаар БНМАУ, Улаанбаатар хотын нутаг цэвсгэр дээр болон гадаад орны нутаг цэвсгарт орших гадаад, дотоодны пүүс, компани, нийгэмлэг, үйлдвэр, аж ахуйн байгууллагуудтай харилцаж гэрээ хэлцэл байгуулах, төлбөр тусгай хийх болон бусад үйл ажиллагаа явуулах эрхийг эцэмнэ.

14. Үүс нь өөрийн үйл ажиллагаа, зуучлалын үндсэн дээр байгуулагдсан үйлдвэр, аж ахуйн газрын ашиг орлого, хийсэн худалдааны орлого, солилцсон бараа, нийлүүлсэн материал түүхийг эд, тоног төхөөрөмжийн үнийн дүн болон гадаадын байгууллагад зуучилсаны орлогын 10 хуртэд хувийг шимтгэн авч пүүсийн эзлэг өргөжүүлэх, бусад зардалд зарцуулах эрхтэй байна. Шимтгэлийн хэмжээг тухай бүр тогтоож байна.

15. Пүүсийн үйл ажиллагаатай холбогдсон эрхийг пүүсийн

захирал болон бусад алсан тушаалтан ажил үүргийнхээ хуваарийн дагуу хэрэгжүүлнэ.

16. Пүүс нь өөрийн үйл ажиллагаа, ашиг сонирхолтой холбогдсон асуудлаар шүүх, арбитрын байгууллагад нэхэмжил гаргах, хариуцагчаар оролцох эрхтэй.

17. Пүүс нь тортоосон журмын дагуу БНМАУ-ын дотор ба хилийн чанадад өөрийн пүүсийн төлөөлөгчдийг түр буюу байнга томилох суулгах буюу буцаан татаж болно.

18. Пүүс нь төрөл бүрийн хэлбэрээр реклам, сурталчилгааны ажил явуулж, холбогдох асуудлаар олон улсын хурал зөвлөлтөөн, гармаг үзэсгэлэнд өөрийн төлөөлөгчийг оролцуулна.

19. Пүүс нь БНМАУ-ын болон бусад улсын банкнд чөлөөт валютын болон үндэсний валютын данстай байх, өөрийн валютын харгалслийг зохих журмын дагуу хуугайгээр халгалуулах, түүнийг өөрийн мэдлээр зарцуулж ашиглах эрх эдэлнэ.

20. Пүүс нь улсын банкны байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр чөлөөт валютын болон үндэсний валютын зээл авах, өөр байгууллагад урт, богино хугацааны зээл олгох, хувь тэмжигчээр оролцох эзрэг санхүү, валют, үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг өрнүүлэн ажиллана.

21. Пүүс нь холбогдох байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр тэдгээрийн зохих мэргэжилтнийг шаардлагатай үед контрактын төсөл боловсруулах, тохиролцох, контракт байгуулахад татан оролцуулж болно.

Цэрэв. Пүүсийн учирдлага

22. Пүүсийн захирал, дэд захирлыг ажилд томилж болон чөлөөлөх асуудлыг Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа шийдвэрлэнэ.

23. Захирал төвлөн удардах зарчмын үндсэн дээр пүүсийн бүх ажилгүйдэл зохихон байгуулан удирдах, түүний үйл ажиллагаа, үр дүнг бүрэн харяуна.

Захирал хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу ажилчин, элсэн хаагчдыг ажилд авах болон ажлаас халах, тэднийг шагнаж урамшуулах, шийтгэх эрхтэй.

24. Захирал нь БНМАУ-ын болон талваадин зохих байгууллагатай пүүсээ төлөөлөн итгэмжлэхгүйгээр харилцах, түүний эд хөрөнгийг тус улсын хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, төрөл бүрийн хэлцэл хийж гэрээ байгуулах, итгэмжлэл олгох, тогтсон журмын дагуу байшинд харилцах болон бусад данс нээх эрхтэй байна.

25. Пүүсийн дэд захирал, мэргэжилтэн, ажилнуудын хариуцах ажил, эрх хэмжээг захирал хуваарилан тогтооно. Эдгээр ажилтнууд пүүсийн төлөө захирлын хариуцлага хүлээхээс үл шалтгаалан хуваарилан даалгасан ажлыг бүрэн хариуцаж, зохих хариуцлага хүлээнэ.

Тав. Пүүсийн өмнөөс гэрээ хэлцэлд гарын үсэг зургах

26. Пүүсээс хийх гэрээ хэлцэлд гарын үсэг зурэх эрхийг захирал, дэд захирал, мэргэжилтэн, түүнчлэн захирлын гарын үсэг бүхий итгэмжлэлийн эрх олгогдсон бусад этгээд эдэлнэ.

27. Пүүсээс олгох вексель, төлбөрийн үүргийн бусад баримтад захирал, дэд захирал, мэргэжилтэн ахлах нягтлан бодохын хамт түүнчлэн захирлын гарын үсэг зурсан итгэмжлэлээр эрх олгогдсон этгээд ахлах нягтлан бодохын хамт гарын үсэг зурна.

28. Пүүсийн эд хөрөнгө нь үндсэн ба эргэлтийн хөрөнгөөс бүрлэх дүрмийн фонд, мөн пүүсийн үйл ажиллагаа, зуучлалын үндсэн дээр бий болсон мөнгөн хөрөнгө, бусад материал, түүхий эд, тоног төхөөрөмж, элийн засгийн урамшлын фонд болон пүүсийн мэдэлд өгсөн бусад хөрөнгөөс бүрлэнэ.

Пүүсийн эд хөрөнгө нь түүний балансад тусгагдана.

Зургаа. Пүүсийн ашиг хуваарилах ба тайлан гаргах

29. Пүүсийн санхүүгийн жилийн I дүгээр сарын I-нээс 12 дугаар сарын 31-нээр тогтооно.

92

30. Пүүсийн тайланг зохих хууль тогтоомжийн дагуу гаргах батална.

31. Пүүсийн үйл ажиллагаа, зуучлалын үндсэн дээр олсон орлого, ашгийг тогтсон журмын дагуу хуваарилна.

32. Пүүсийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааг хянан шалгах аялыг БМАУ-ын хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ.

Долоо. Пүүсийг өөрчлөн байгуулах ба татан буулгах

33. Пүүсийг өөрчлөн байгуулах болон татан буулгах асуудлыг Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа шийдвэрлэнэ.

793

Улаанбаатар хотын Ардын Хурлын  
гуйцэтгэх захиргааны 1990 оны  
888 тоот тогтоолын хоёрдугаар  
хэвсрэлт

"ТУУЛ ИМЛЭХС" ДҮҮСИЙН ОРОН ТОО,  
ЦАЛИНГИЙН САН

№	Албан тушаал	Тоо	Сарын цалин	Сарын цалин- гийн сан
1.	Захирал	1	1100	1100
2.	Ахлах нягтлан бодогч	1	800-900	850
3.	Гэрээ эрхийн мэргэжилтэн	1	750-850	800
4.	Бараа солилцооны мэргэжилтэн	1	750-850	800
5.	Эдийн засаг, техникийн хам- тын ажиллагааны асуудал ха- риуцсан мэргэжилтэн	1	750-850	800
6.	Орчуулагч /англи, хятад/	2	750-850	1600
	ДҮН	8		5950